Эх сурвалж: Мөнгөн гүйцээний тайлангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 223370.8 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 223370.8 мянган төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Хангал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд 2021 онд богино хугацаат хөрөнгө оруулалт, үнэт цаас, бондын эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 297.6 сая, эцсийн үлдэгдэл 307.8 сая төгрөг болж, 10.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	39.2	6648.6	6609.4
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага		54724.5	54724.5
Зээлийн хүүгийн авлага		658.9	658.9
Бусад авлага	297609.4	245814.1	-51795.3
Зээлийн авлага			
Дүн	297648.6	307846.1	10197.5

Эх сурвалж: Авлагын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 212268.6 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Ямар шалтгаантай үүссэн: Сум хөгжүүлэх сангийн 3 жилийн хугацаатай зээлийн 212268.6.сая төгрөгийн авлага байна.

Эдгээр нь найдваргүй авлага үүссэн үр дагавартай байна.

Хүснэгт № 3 Авлагын задаргаа /сая төгрөг/

Код	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бу. Ха. Сум хөгжүүлэх сан	277,417.4	84,895.7	170,128.6	192,184.5
2	Бу. Ха. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	17,192.0	55,543.4	14,048.9	58,686.5
3	Бу. Ха. Иргэдийн төлөөлөгчдийн хурал		342.3	324.5	17.7
4	Бу. Ха. Засаг даргын тамгын газар	39.2	2,473.9	921.6	1,591.5
5	Бу. Ха. Цэцэрлэг	3,000.0	1,250.8	4,250.8	55,326.09
6	Бу. Ха. Соёлын төв		516.4	516.4	39.9
7	Бу. Ха. Хүн эмнэлэг		56,339.6	1,013.5	
8	Бу. Ха. Сургууль		39.9		
Нийт		297,648.6	201,402.2	191,204.5	307,846.2

5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 299312.2 мянган, эцсийн үлдэгдэл 436368.7 мянган төгрөг болж, 137056.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	3,267.5	20,536.4	17,268.9
Бэлэн бүтээгдэхүүн		1,472.9	1,472.9
Бичиг хэргийн материал	9,424.7	10,211.5	786.8
Аж ахуйн материал	47,617.4	83,771.3	36,153.9
Сэлбэг хэрэгсэл	23,377.2	26,679.3	3,302.1
Түлш шатах, тослох материал	3,881.0	3,180.9	(700.1)
Барилгын засварын материал	6,376.1	5,917.4	(458.7)
Хүнсний материал	1,008.9	7,194.1	6,185.2
Бусад хангамжийн материал	187,155.4	260,093.9	72,938.5
Мал амьтад	17,204.0	17,311.0	107.0
Дүн	299,312.2	436,368.7	137,056.5

Эх сурвалж: Бараа материалын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авч 260610.3 мянган төгрөгийн эргэлтийн бараа материалыг тогтвортой үйл ажиллагааг хангах шалтгаанаар нөөцөлсөн. /Байгаль хамгаалах сан 37202.5 сая, ИТХ- 4298.6 сая ЗДТГазар 43216.6 сая ,Цэцэрлэг - 17955.1 сая, Соёлын төв - 1702.9 сая, Хүн эмнэлэг - 126766.9 сая, Сургууль -29467.7 сая төгрөг/

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5535287.8 мянга, эцсийн үлдэгдэл 5596917.4 мянган төгрөг болж, 61629.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

БУА-2022/12/СТА-ТТЗ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,515,707.7	4,521,572.7	5,865.0
Тээврийн хэрэгсэл	223,859.7	199,821.8	(24,037.9)
Машин тоног төхөөрөмж	275,142.2	326,788.5	51,646.3
Тавилга эд хогшил	286,813.0	293,500.0	6,687.0
Зам гүүрний байгууламж	4,833.3	1,500.0	(3,333.3)
Түүх соёлын дурсгалт зүйл	90,000.0	90,000.0	-
Номын фонд	22,960.5	22,960.5	-
Бусад үндсэн хөрөнгө	51,126.5	74,579.1	23,452.6
Программ хангамж	10,286.9	10,856.8	569.9
Бусад биет бус хөрөнгө	54,558.0	55,338.0	780.0
Дүн	5,535,287.8	5,596,917.4	61,629.6

Эх сурвалж: Үндсэн хөрөнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 78978.8 мянга, балансаас балансад шилжүүлэн авсан 4113.3 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 1650.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 4113.3 мянга, худалдсан 60000.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэлгүй эцсийн үлдэгдэл 27383.3 мянган төгрөг болж, 27383.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	0	27,383.30	27,383.30	100
ажилчидтай холбоотой өглөг	0	8,725.40	8,725.40	32
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	18,000.20	18,000.20	66
Байгууллагад төлөх өглөг	0		-	
Хувь хүмүүст төлөх өглөг	0	657.60	657.60	02
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	0	0	0	
Нийт дүн	0	27383.30	27383.30	100

Эх сурвалж: Өр төлбөрийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 27383.2 мянган төгрөгийн өр байна.

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бу. Ха. Сум хөгжүүлэх сан	0	257.50		257.50
2	Бу. Ха. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0	75,068.30	75,068.30	
3	Бу. Ха. Засаг даргын тамгын газар	0	548,673.40	548,673.40	
4	Бу. Ха. Цэцэрлэг	0	182,014.10	182,014.10	
5	Бу. Ха. Соёлын төв	0	78,067.90	78,067.90	
6	Бу. Ха. Хүн эмнэлэг	0	539,789.90	512,664.10	27,125.80

7	Бу. Ха. Сургууль	0	636,701.80	636,701.80	
Нийт		0	2,060,572.90	2,033,189.60	27,383.30

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3384854.0 мянга, эцсийн үлдэгдэл 3462784.1 мянган төгрөг болж, 77930.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	824232.9	824232.9	0	0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	0	0	0
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0	0	0	0
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	0	0	0	0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	0	0	0	0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0	0	0	0
Хуримтлагдсан үр дүн	1524928.9	1563862.1	38933.2	100
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0	0	0	0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0	0	0
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0	0	0	0
Дүн	2349161.8	2388095.0	38933.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2388095.0 мянган төгрөг болж 38933.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Хувийн өмчийн дансны үлдэгдэл 1563862.1 мянган төгрөг болж 38933.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.10 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого спорт заалнаас 2252.3 мянга, соёлын үйл ажиллагаанаас 312.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

3.5.11 Зардлын данс

Зардлын дансадтай холбоотой ТШЗ нарт санхүүгийн тайлангийн уядлаа холбоо, зардал, авлага өглөг, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой нийт 755272.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Тухайлбал: Төсвийн үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан ЕБС бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1015.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж үндсэн хөрөнгөнд орлогод авсан, хүүхдийн цэцэрлэгийн тээвэр шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэлгүй шатахуун олгосон, тэтгэвэрт гарсан багш эрхлэгчээ хавсран гүйцэтгэхдээ хөдөлмөрийн гэрээ байгуулсан боловч үндэслэлгүйгээр цалинг нэмж олгосон зэрэг үрэлгэн зарцуулсан гэх мэт зардлын данстай холбоотой нийтлэг алдаа илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хангал сумын цэцэрлэгийн багш, эрхлэгч Ж.Цэрмаа нь тэтгэвэрт гарч үргэлжлүүлэн ажиллахаар хөдөлмөрийн гэрээг 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Засаг дарга М.Төмөрбаттай байгуулж цалинг багшийн үндсэн цалин /818,762 төгрөг/ дээр эрхлэгчийн цалингийн 885,763*40 хувь 354305.2 төгрөг нэмж

- олгохоор заасан боловч үндэслэлгүйгээр 326,932.8 төгрөгийг нэмж 1,500,000 төгрөгөөр тохиролцож олгосон байна.
- Хангал сумын цэцэрлэгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг тогооч ажилтай Н.Цагаанчулууныг хагалгаанд орж эмчилгээ хийлгэхэд 400,000 төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон боловч цэцэрлэгийн дотоод журмын 3.11 дүгээр зүйл "нэг гэрт хамтран амьдардаг асрамжид байдаг дотны хүн /эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд, эцэг эх, ах эгч/ нас барсан болон хүнд өвчтэй тохиолдолд 50,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгож 3-5 хоногийн цалинтай чөлөө олгоно" гэж заасан заалтаар тушаал гаргаж олгосон
 - Хангал сумын ЕБС-ийн туслах аж ахуйгаас ямаа 28, хонь 7, үхэр 2 ширхэг нийт 2815000 төгрөгийн хөрөнгийн зарцуулалт гарсан боловч зарцуулалтын тайлан, илтгэх хуудасгүй нотлох баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасан заалтыг зөрчсөн
 - Хангал сумын Соёлын төвийн СТС санхүүгийн программын сургалтад Бугат сум руу явсан боловч удирдамж, хөтөлбөр буюу нотлох баримтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн.
 - Хангал сумын ЭМТ-ийн цалингийн урьдчилгааг 34713 дансаар, өглөгийг авлагын дансанд журналын бичилт хийж тайлагнасан нь НБББББ-ын 5.10, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй
 - Хангал сумын эрүүл мэндийн төвийн дарга сумын Засаг даргын захирамжгүйгээр өөрөө 2021 оны 08 дугаар сарын 05-ны Б/20, 10 дугаар сарын 13-ны Б/25 дугаар тушаалаар 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 -т "хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох" заалтыг зөрчсөн.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

/Хангал сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай VI/20 дугаар тогтоолд/ зааснаар Засаг дарга М.Төмөрбат тайлант онд 123087.2 сая төгрөгийн орлого улсын /орон нутгийн / төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 176043.85 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 143.02 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мян. төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	7000.0	6140.52	859.48	87.7
Шууд бус орлого	23000.0	13950.83	9049.17	60.6
916.962-р данс иргэний үхх борлуулсны албан татвар		17554.24	17554.24	100
Хөрөнгийн албан татвар	7000.0	6556.28	443.72	93.6

Бууны албан татвар	1170.0	774.0	396.0	66.1
Улсын тэмдэгтийн хураамж	6000.0	8172.43	-2172.43	136.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	35000.0	33215.0	1785.0	94.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4000.0	3790.54	209.46	94.7
Газрын төлбөр	2304.8	12667.58	10362.25	549.7
Ойн нөөц ашигласны төлбөр	20112.4	41045.65	-20933.25	204
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6100.0	6753.5	653.5	110.7
Хүүгийн орлого, торгууль	10000.0	21961.61	-11961.61	219.6
Төсөв байгууллагын өөрийн орлого	400.0	534.84	-134.84	133.5
нэр заагдаагүй бусад орлого	1000.0	2926.82	-1926.82	292.6
Нийт дүн	123087.2	176043.85	-52956.65	143.02

Төвлөрүүлэх орлого 52956.6 мянган төгрөгөөр давсан ойн нөөц ашигласны төлбөр, хүү, торгууль орлогоос шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 906825.8 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 813061.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29000.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 277629.2 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн 148834.7 мянган төгрөгөөр бууруулж 1877682.03 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь орон нутгийн төсөв болон үндсэн үйл ажиллагааны зардлыг бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2017016.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2017006.8 сая төгрөгийг урсгал зардалд, 10 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2017016.8 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 813061.8 сая төгрөгийг улсын /орон нутгийн төсвөөс, 906825.8 сая төгрөгийг тусгай зорилтын шилжүүлгээс 29000.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 0.4 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 828315.9 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 828602.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18083.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 202679.4 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого нийт 1877682.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 202679.4 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 46779.4 мянган төгрөгөөр давсан нь ойн нөөц ашигласны төлбөр, газрын төлбөр, тэмдэгтийн хураамж, иргэний үндсэн хөрөнгө болон бараа материал борлуулсны татварыг давуулан биелүүлсэн нь шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 0.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0.1 сая төгрөгөөр давсан халуун усны үнэ нэмэгдсэн шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1809155.5 мянган төгрөг буюу 89.7 хувьтай байгаа нь ковид цар тахалтай холбоотойгоор сургууль цэцэрлэг ажиллаагүйтэй холбоотой байна. Үүнд:

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ИТХурал	71,348.8	67,207.6	(4,141.2)	94.2
ЗДТГазар	463,491.2	441,701.7	(21,789.5)	95.3
Соёлын төв	69,517.1	64,801.7	(4,715.4)	93.2
ЕБС	560,338.4	528,746.7	(31,591.7)	94.4
Цэцэрлэг	168,410.2	130,517.7	(37,892.5)	77.5
ЭМТөв	382,483.3	370,658.5	(11,824.8)	96.9
СХСан	160,782.3	102,921.9	(57,860.4)	64.0
ЖДҮДСан	17,554.1	17,600.0	45.9	100.3
БХСан	38,044.9	37,953.9	(91.0)	99.8
ОНХСан	85,046.5	47,045.8	(38,000.7)	55.3
	2,017,016.8	1,809,155.5	(207,861.3)	

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 78991.7 мянган төгрөгийг улсын төсөв, 922.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 85046.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 47046.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, барьцаа дансанд, захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 16 иргэдээс 10692.4 мянга, Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгө/-гаас 16000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 93616.7 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 47910.8 мянга, нийт 168219.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ЗДТГазарт.-д 68376.8 мянга, ЭМТ-д 94362.458 мянга, ЕБС-д 2315.6 мянга, Цэцэрлэгт 180.0 мянган төгрөг нийт 165234.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 4300.0 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилтийг 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/711 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Биелэгдээгүй	Хэрэгжилтийн хувь
----------	---------------------	---------	--------------	-------------------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	3	4300.0	0	0	0
Нийт							

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллага түүврээр хамрагдсан, 0 байгууллага аудитад хамруулсан байна..

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, “Хязгаарлалттай” болон “Сөрөг” “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлт авсан байгууллага байхгүй байна.

Аудитаар нийт 19522.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3637.2 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15884.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ залруулга хийгдээгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн төлбөрийн акт

1. Малын хөлийн татвар нь 30000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 30170.3 мянган төгрөгийг төвлөрүүлж 170.3 мянган төгрөгөөр илүү төлсөн байна. Жилд орох орлогыг тооцож үзэхэд 33501.06 мянган төгрөг үүнээс 50 өрхийн 1246.8 мянган төгрөгийн малын хөлийн татвар төлөгдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

2. 2021 онд бууны албан татвар нийт 39 буунаас 1170.0 мянган төгрөгийн татвар хураахаас 26 буунаас 774.0 мянган төгрөг татвар авсан байна. 396.0 мянган төгрөгийн татварыг дутуу хураасан.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

3. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө нь 35000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 33215.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 1785.0 мянган төгрөгийн төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь Гокоос эргэлтийн усны 3 дугаар шугам тавих ажил зогссонтой холбоотой төлөвлөгөө тасарсан байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

4. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 4000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 3790.5 мянган төгрөгийг төвлөрүүлж 209.4 мянган төгрөгийн төлөвлөгөө тасарсан байна.

5. Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага бичигдээгүй.

Төвлөрүүлсэн захирагчид 15884.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 7 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 316505.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1200.3 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 309192.9 мянган төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 6112.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хангал сумын төвлөрүүлэн захирагчид орлогын төлөвлөгөөг таслахгүй байх, төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөж байх, сангийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулж ажиллах, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн уялдаа холбоо, гарсан зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах зэргийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 7000.0 мянган төгрөгөөр батлагдаж тайлант онд гүйцэтгэлээр 6140.5 мянган төгрөгийг төвлөрүүлж 859.5 мянган төгрөгөөр орлого тасарсан байна.

3.1.2 Эрсдэл: Алдагдалтай ажиллах, үр ашиг буурах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.2 Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Хөрөнгийн орлогын төлөвлөгөө нь 7000.0 мянган төгрөг оруулахаас 6556.3 мянган төгрөгийг төвлөрүүлж 443.7 мянган төгрөгөөр орлого тасарсан байна. Энэ нь иргэдийн хадгаламжийн хүүгээс 10 хувийн татвар авч орлого бүрдүүлдэг боловч Хаан банк, Төрийн банкны хадгаламжийн хүү буурснаар төлөвлөгөө тасарсан шалтгаантай байна.

3.2.2 Эрсдэл: Алдагдалтай ажиллах, үр ашиг буурах

3.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.3 Орлогын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт: Иргэдээс худалдан авалт хийсэн 10 хувийн татвар буюу шууд бус орлогын төлөвлөгөө 23000.0 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 13950.8 мянган төгрөгийг төвлөрүүлж 9049.2 мянган төгрөгөөр тасарсан байна. ажиллаагүй.

3.3.2 Эрсдэл: Алдагдалтай ажиллах, үр ашиг буурах

3.3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрдөж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

3.4 Авлагын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт: Хугацаа хэтэрсэн Баг хөгжүүлэх сангаас 2015-2020 онд зээл авсан 5 иргэний 2989.4 мянган төгрөг, төрийн албан хаагчид олгосон ЖДҮДС-гийн зээлийн авлагыг барагдуулаагүй байна.

3.4.2 Эрсдэл: Алдагдалтай ажиллах, үр ашиг буурах

3.4.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

3.5 ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.5.1 Илрүүлэлт: Улсын тэмдэгтийн хураамжийг 6000.0 мянган төгрөгөөр батлагдаж тайлант онд гүйцэтгэлээр 8172.4 мянган төгрөгийг төвлөрүүлж 2172.4 мянган төгрөгийн орлогыг илүү төвлөрүүлсэн, газрын төлбөрийг 2304.8 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 12667.6 мянган төгрөгийг төвлөрүүлж 10362.7 мянган төгрөгийг илүү төвлөрүүлсэн байна. Энэ нь Орхон аймгийн 78 объект Хангал сумын нутаг дэвсгэрт байдаг өмнөх оны газрын төлбөрийг төлөгдөөгүй байсан төлбөрийг тайлант онд төлсөн байна. Ойн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөөг 20112.4 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 41045.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Илүү төвлөрүүлсэн 20933.2 мянган төгрөгийг гоожийн төлбөр төлөхөд авдаг шимтгэлийн үнэ мөн иргэдэд тэжээлийн хашаа барихад хашааны мод олгосон нь илүү төвлөрүүлэх шалтгаан болсон байна. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 6100.0 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 6753.5 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна. Илүү төвлөрүүлсэн 653.5 мянган төгрөг энэ нь ГОК-оос 5000.0 мянган төгрөг орж, төрөөс ус цахилгааны төлбөрийг даасантай холбоотой 1753.5 мянган төгрөгийг буцаан төлсөн шалтгаанаар төвлөрсөн. Хүүгийн орлого 10000.0 мянган төгрөгийг оруулахаас гүйцэтгэлээр 21961.6 мянган төгрөгийг төвлөрүүлжээ. Илүү төвлөрүүлсэн 11961.6 мянган төгрөгийг хууль бус газар эзэмшлийн торгууль, хулгайн модны торгууль, авто тээврийн хэрэгслээр зөрчил гаргасан жолооч нарын торгуулиас илүү төлөлт үүссэн байна. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэлээр 17554.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Илүү төвлөрүүлсэн орлогын төлөвлөгөөг судалгаа тооцоололгүйгээр төлөвлөж баталсан байна.

3.5.2 Эрсдэл: Алдагдалтай ажиллах, үр ашиг буурах

3.5.3 Өгсөн зөвлөмж: Төлөвлөгөөг тооцоо судалгааны үндсэн дээр төлөвлөж байх.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.6 Төсвийн шууд ЗАХИРАГЧИЙН ГАРСАН АЛДАА ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.6.1 Илрүүлэлт: ТШЗ нарт санхүүгийн тайлангийн уядлаа холбоо, зардал, авлага өглөг, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой нийт 755272.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

3.6.2 Эрсдэл: Өмнөх оны алдаа зөрчлийг давтан гаргах

3.6.3 Өгсөн зөвлөмж: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.7 Шилэн данстай ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.7.1 Илрүүлэлт: Тус байгууллагын 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд 153 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2022.03.18	Аудитын нэр:	Булган аймгийн Хангал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	Аудитын код: БУА-2022/12/НА- СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хангал сумын Засаг дарга		төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 7000.0 мянган төгрөгөөр батлагдаж тайлант онд гүйцэтгэлээр 6140.5 мянган төгрөгийг төвлөрүүлж 859.5 мянган төгрөгөөр орлого тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь,	859477.72	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа

	төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллаагүй.				
2	Хөрөнгийн орлогын төлөвлөгөө нь 7000.0 мянган төгрөг оруулахаас 6556.3 мянган төгрөгийг төвлөрүүлж 443.7 мянган төгрөгөөр орлого тасарсан байна. Энэ нь иргэдийн хадгаламжийн хүүгээс 10 хувийн татвар авч орлого бүрдүүлдэг боловч Хаан банк, Төрийн банкны хадгаламжийн хүү буурсанаар төлөвлөгөө тасарсан шалтгаантай байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллаагүй.	443716.61	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
3	Иргэдээс худалдан авалт хийсэн 10 хувийн татвар буюу шууд бус орлогын төлөвлөгөө 23000.0 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 13950.8 мянган төгрөгийг төвлөрүүлж 9049.2 мянган төгрөгөөр тасарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрдөж ажиллаагүй.	9049172	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
4	Хугацаа хэтэрсэн Баг хөгжүүлэх сангаас 2015-2020 онд зээл авсан 5 иргэний 2989.4 мянган төгрөг, төрийн албан хаагчид олгосон ЖДҮДС-гийн зээлийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллаагүй байна.	5,532,494.00	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа

5	<p>Улсын тэмдэгтийн хураамжийг 6000.0 мянган төгрөгөөр батлагдаж тайлант онд гүйцэтгэлээр 8172.4 мянган төгрөгийг төвлөрүүлж 2172.4 мянган төгрөгийн орлогыг илүү төвлөрүүлсэн, газрын төлбөрийг 2304.8 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 12667.6 мянган төгрөгийг төвлөрүүлж 10362.7 мянган төгрөгийг илүү төвлөрүүлсэн байна. Энэ нь Орхон аймгийн 78 объект Хангал сумын нутаг дэвсгэрт байдаг өмнөх оны газрын төлбөрийг төлөгдөөгүй байсан төлбөрийг тайлант онд төлсөн байна. Ойн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөөг 20112.4 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 41045.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Илүү төвлөрүүлсэн 20933.2 мянган төгрөгийг гоожийн төлбөр төлөхөд авдаг шимтгэлийн үнэ мөн иргэдэд тэжээлийн хашаа барихад хашааны мод олгосон нь илүү төвлөрүүлэх шалтгаан болсон байна. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 6100.0 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 6753.5 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна. Илүү төвлөрүүлсэн 653.5 мянган төгрөг энэ нь ГОК-оос 5000.0 мянган төгрөг орж, төрөөс ус цахилгааны төлбөрийг даасантай холбоотой 1753.5 мянган төгрөгийг буцаан төлсөн шалтгаанаар төвлөрсөн. Хүүгийн орлого 10000.0 мянган төгрөгийг оруулахаас гүйцэтгэлээр 21961.6 мянган төгрөгийг төвлөрүүлжээ. Илүү төвлөрүүлсэн 11961.6 мянган төгрөгийг хууль бус газар эзэмшлийн торгууль, хулгайн модны торгууль, авто тээврийн хэрэгслээр зөрчил гаргасан жолооч нарын торгуулиас илүү төлөлт үүссэн байна. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэлээр 17554.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Илүү төвлөрүүлсэн орлогын төлөвлөгөөг судалгаа тооцоололгүйгээр төлөвлөж баталсан байна.</p>	0	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
6	<p>Тус байгууллагын 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд 153 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна</p>	0	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
7	<p>ТШЗ нарт санхүүгийн тайлангийн уядлаа холбоо, зардал, авлага өглөг, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой нийт 755272.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.</p>	0	Зөвлөмж өгөх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа

Хангал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	Малын хөлийн татвар нь 30000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 30170.3 мянган төгрөгийг төвлөрүүлж 170.3 мянган төгрөгөөр илүү төлсөн байна. Жилд орох орлогыг тооцож үзэхэд 33501.06 мянган төгрөг үүнээс 50 өрхийн 1246.8 мянган төгрөгийн малын хөлийн татвар төлөгдөөгүй байна.	1,246,820.00	Төлбөрийн акт	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
9	2021 онд бууны албан татвар нийт 39 буунаас 1170000 төгрөгийн татвар хураахаас 26 буунаас 774000 төгрөг татвар авсан байна. 396000 төгрөгийн татварыг дутуу хураасан.	396,000.00	Төлбөрийн акт	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө нь 35.000.000 төгрөг, гүйцэтгэлээр 33.215.000 төгрөгийг төвлөрүүлж 1.785.000 төгрөгийн төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь Эрдэнэт үйлдвэрээс эргэлтийн усны 3 дугаар шугам тавих ажил зогссонтой холбоотой төлөвлөгөө тасарсан байна.	1,785,000.00	Төлбөрийн акт	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
11	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 4.000.000 төгрөгийг төвлөрүүлэхээс 3.790.542 төгрөгийг төвлөрүүлж 209.458 төгрөгийн төлөвлөгөө тасарсан байна.	209,458.00	Төлбөрийн акт	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	М.Төмөрбат Б.Алтанзаяа
	Дүн	19522138.33			